



Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын
11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан
“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

“УВС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Жилийн үйл ажиллагааны тайлан	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр: “Увс Хүнс” Хувьцаат компани УБГД: 1510001008, РД: 2001969 Үнэт цаасны код: HUN Хаяг: Увс аймаг, Улаангом сум, 5-р баг Утас: +976-7555-8686 Имэйл: info@uvskhuns.mn Вэб хаяг: www.uvskhuns.mn
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Хүнсний үйлдвэрлэл, газар тариалан
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	112,716
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Жилийн тайлан бэлтгэсэн: Захиргаа, хүний нөөцийн албаны дарга О.Оюунхүү Хянасан: Гүйцэтгэх захирал Л.Нямгэрэл



1.	Жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт	2025.01.01	2025.12.31
	Хөрөнгө		мян.төг
	Эргэлтийн хөрөнгө	3,029,878.9	4,529,412.4
	Эргэлтийн бус хөрөнгө	1,880,635.2	1,823,979.8
	Нийт хөрөнгө	4,910,514.1	6,353,392.2
	Өр төлбөр ба эздийн өмч		
	Богино хугацаат өр төлбөр	441,903.6	250,297.6
	Эздийн өмч	4,468,610.5	6,103,094.6
	Нийт өр төлбөр ба эздийн өмч	4,910,514.1	6,353,392.2
Орлогын тайлан	Үзүүлэлт	2025.01.01	2025.12.31
	Борлуулалтын орлого	5,592,134.4	7,798,624.8
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,206,906.5	4,417,453.8
	Нийт ашиг	2,385,227.9	3,381,171.0
	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	1,049,834.2	1,819,054.6
	Орлогын албан татварын зардал	107,123.1	184,570.5
	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	942,711.1	1,634,484.1
			мян.төг
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт	2025.01.01	2025.12.31
	Энгийн хувьцаа/НТК	14,736.7	14,736.7
	Дахин үнэлгээний нэмэгдэл	847,420.5	847,420.5
	Эздийн өмчийн бусад хэсэг	179,179.7	179,179.7
	Хуримтлагдсан ашиг	3,427,273.6	5,061,757.7
	Нийт эздийн өмчийн дүн	4,468,610.4	6,103,094.6



		мян.төг	
		2025.01.01	2025.12.31
Мөнгөн гүйлгээний тайлан	Үзүүлэлт		
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	969,413.7	516,521.7
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(51,227.6)	(190,464.0)
	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(783,025.8)	(275,000.0)
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	136,153.4	(52,712.9)
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,394.1	165,547.4
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	165,547.4	218,260.3
2.	Жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт		
	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж дүгнэлт гаргадаг. Жилийн тайланг Гүйцэтгэх захирлаар батлуулсан.		
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан дүгнэлт		
3.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт ашгийн хувь	42.6% 43.3%
		Цэвэр ашгийн хувь	16.8% 20.9%
3.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа	6.8 18
		Түргэн хөрвөх чадварын харьцаа	2.4 4.6
		Өрийн харьцаа	0.1 0.04




3.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүний үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөнд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл	
3.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээ байхгүй.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.	
5.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэлурамшууллын мэдээлэл	
	Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.	
6.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	



	Хувьцаа эзэмшигчдийн хурал “Увс Хүнс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Увс аймаг Улаангом сум 5-р баг компанийн байр захирлын өрөөнд хуралдан дараах шийдвэрүүдийг гаргасан. Үүнд: 1. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дүгнэн батлав. 2. 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлав. 3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг улируулан сонгов. “УВС ХҮНС” Хувцаат Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүд: - Л.Мөнхнаран - Т.Лхагвасүрэн - Л.Нямгэрэл - Л.Мөнхтуяа - Л.Энхтуяа - Л.Батмөнх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүд: - А.Чимпд-Очир - Ж.Бааст - Н.Оюун		
7.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл		
	Тайлант хугацаанд Компанийн засаглалын кодексийн тайланг 2025 оны 04 сарын 25-ны өдөр МХБ-ийн сайтад байршуулсан. Компанийн засаглалын кодексийн хүрээнд: 1. Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны даргаар хараат бус гишүүд томилсон. Компанийн засаглалын хүрээнд дараах дүрмийг шинээр батлан мөрдөн ажиллаж байна. Үүнд: 1. Ёс зүйн дүрэм		
8.	Үйл ажиллагаатай холбоотой нэмэлт мэдээлэл		
	<table border="1"> <tr> <td data-bbox="206 1579 474 1839">Хүний нөөц</td><td data-bbox="474 1579 1506 1839"> 2025 оны 12 сарын 31-ний байдлаар нийт 85 ажилтан ажилласан бөгөөд 24 эрэгтэй, 61 эмэгтэй ажилтан ажиллаж байна. Дундаж наслалт 35 10 удаагийн онлайн болон танхимын цагийн сургалтад хамрагдсан. Хагас жилд 7 ажилтан шинээр ажилд орсноос 5 ажилтан ажлын байран дээрээ дадлагажиж жинхэлсэн, 2 оюутан үйлдвэрлэлийн дадлага хийсэн. Ажиллагсдын амралтын өрөөний тохижилт хийгдсэн. </td></tr> </table>	Хүний нөөц	2025 оны 12 сарын 31-ний байдлаар нийт 85 ажилтан ажилласан бөгөөд 24 эрэгтэй, 61 эмэгтэй ажилтан ажиллаж байна. Дундаж наслалт 35 10 удаагийн онлайн болон танхимын цагийн сургалтад хамрагдсан. Хагас жилд 7 ажилтан шинээр ажилд орсноос 5 ажилтан ажлын байран дээрээ дадлагажиж жинхэлсэн, 2 оюутан үйлдвэрлэлийн дадлага хийсэн. Ажиллагсдын амралтын өрөөний тохижилт хийгдсэн.
Хүний нөөц	2025 оны 12 сарын 31-ний байдлаар нийт 85 ажилтан ажилласан бөгөөд 24 эрэгтэй, 61 эмэгтэй ажилтан ажиллаж байна. Дундаж наслалт 35 10 удаагийн онлайн болон танхимын цагийн сургалтад хамрагдсан. Хагас жилд 7 ажилтан шинээр ажилд орсноос 5 ажилтан ажлын байран дээрээ дадлагажиж жинхэлсэн, 2 оюутан үйлдвэрлэлийн дадлага хийсэн. Ажиллагсдын амралтын өрөөний тохижилт хийгдсэн.		



XVII жарны “Элдэв эрдэнэт” хэмээх модон могой жилийн хаврын тэргүүн сарын мэндийг дэвшүүлэн сар шинийн үзэсгэлэн худалдаанд оролцов.



“Европын Өдөрлөг-2025” арга хэмжээнд Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газраас жил бүр зохион байгуулдаг “Европын өдөрлөг” арга хэмжээ энэ жил 2025 оны 05-р сарын 17-нд Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэнд зохион байгуулагдан оролцсон.

#ЕвропынӨдөрлөг2025 #УвсХүнсХК #ЧаацарганыКластер #UvsKhuns
#EUinMongolia #Увсчаацаргана





GreenerZ PopUp Festival I Увс Хүнс ХК/ Uvs Khuns JSC

Байгальдаа ээлтэй үйлдвэрлэгч, хэрэглэгч хамтдаа тэмдэглэх GreenerZ PopUp Festival-д үндэсний ууган үйлдвэрлэгч, 83 жилийн түүхтэй “Увс хүнс” ХК нэгдлээ.

Экологийн цэвэр түүхий эдийг дэвшилтэт технологиор боловсруулснаар УВС ХҮНС ХК нь хог хаягдал багатай, нөөцийн хэмнэлттэй, байгальдаа ээлтэй ногоон үйлдвэрлэлд амжилттай шилжиж буй юм.

Зохион байгуулагч: Эдийн Засгийн Ногоон Шилжилт төсөл

Дэмжигч: Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам

EU Delegation to Mongolia

EU SWITCH-Asia Programme

Development Solutions NGO - Хөгжлийн Шийдэл ТББ

ToC Холбоо / MSFA

People in Need - PIN Mongolia

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам





Татвар төлөгчдийн өдрүүдийн хүрээнд Увс Аймгийн Татварын газраас Улс орныхоо хөгжлийг дэмжиж, төсвийн орлогыг бүрдүүлэх үүргээ нэр төртэй биелүүлж буй 2025 оны шилдэг татвар төлөгчдөд талархал илэрхийлж "Увс Хүнс" ХК шалгарсан.

ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН
ӨДРҮҮД 2025

ЗӨВЛӨН
ТУСЛАГЧ
ТАТВАРЫН АЛБА

ТАЛАРХАЛ
Увсхүнс ХК

Монгол Улсын Үндсэн хуульд заасан татвар төлөх үндсэн
үүргээ ёсчлон биелүүлж 2024 онд улс, орон нутгийн төсөвт

885,146,992.0

төгрөгийн татвар төлсөн, үнэ цэнтэй,
хариуцлагатай татвар төлөгч танд
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЬЕ.

Монголын татварын алба
2025.05.08





Манай компани нь Европын Холбооны санхүүжилттэй 2025 оны 05-11 сарын хооронд 6 сарын хугацаатай Эдийн Засгийн Ногоон Шилжилт төслийн хүрээнд зарлагдсан менторшип хөтөлбөрт шалгарсан 24 байгууллагын нэг болж өдгөө Байгаль Орчин Нийгэм Засаглал /БОНЗ/-г хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээг авч эхлээд байна.

Европын Холбооны санхүүжилттэй “Эдийн засгийн ногоон шилжилт” төслийн баг 2025 оны 06-р сарын 24-27-нд Увс аймгийн Улаангом хотод ажиллаж, БОНЗ (Байгаль орчин, нийгэм, засаглал)-ын хэрэгжилтийн талаар газар дээр нь танилцсан.

Ногоон ирээдүйг хамтдаа бүтээцгээе 🌍

EU Delegation to Mongolia

EU SWITCH-Asia Programme

Development Solutions NGO - Хөгжлийн Шийдэл ТББ

ToC Холбоо / MSFA

Увс Ххаа-н Газар

Увс Хүнс ХК



ISA 2025 Олон улсын Чацарганы хуралд оролцсон.

Увс Хүнс ХК 2025 оны 09-р сарын 01-05ны өдрүүдэд БНХАУ-ын Ордос хотод зохион байгуулагдсан Олон улсын чацарганы холбооны 10 дугаар чуулганд амжилттай оролцсон.

Хоёр жил тутамд дэлхийн Чацарганачид хуран чуулж чацарганын хамгийн сүүлийн үеийн судалгаа, ололт амжилт, инновац, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, технологийн чиг хандлагын талаарх мэдээ, мэдээлэл хуваалцдаг. Манай компани уг хуралтай зэрэгцэн явагддаг үзэсгэлэнд Чацаргана бүтээгдэхүүний зарим төрлүүдээс танилцуулж, олон улсын сайн туршлага, шинэлэг санаанаас суралцсан юм. Мөн Увс Хүнс ХК-ийн Стратеги, төлөвлөлт, инновацын захирал З.Цэцэгсүвд “Exploring Geographical Indication: The Seabuckthorn Access Case” сэдвээр илтгэл тавьж, Монголын чацаргана, тэр дундаа Увс нуурын ай савд ургасан Чацарганы онцлог, түүгээр хийсэн бүтээгдэхүүний шинж чанарын талаар Дэлхийн 10 гаруй орны Чацарганы оролцогч талуудад мэдээлэл түгээсэн.






Канадын Calgary хотод жил бүр зохион байгуулагддаг "Spruce Meadows" шинэ жилийн худалдааны үеэр Монголын соёл уламжлал, бараа бүтээгдэхүүнийг танилцуулах үзэсгэлэн худалдааны үеэр Чацарганы шүүс, чихэр, чанамал зэрэг бүтээгдэхүүний амталгаа, сурталчилгаа явагдсан.





НҮБ-н Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ)-аас жил бүрийн 10 дугаар сард Итали Улсын Ром хотноо Дэлхийн хүнсний форумыг зохион байгуулдаг. Энэ жил уг байгууллагын 80 жилийн ой тохиож буйтай холбогдуулан “from Seeds to Foods” үзэсгэлэн, амталгааг зохион байгуулсан. Дэлхийн 180 гаруй орны төлөөлөгчид болон иргэдэд манай компанийн төлөөлөл Газарзүйн заалттай Увсын Чацарганатай бүтээгдэхүүний онцлог, ач холбогдолын талаар мэдээлэл түгээж амталгаа хийлгэсэн. Герман технологиор хийдэг сахарын орц багатай “Улаангом” Чацарганын чанамалыг эрүүл амьдралыг эрхэмлэгчид зорьж ирэн амталсан, хамгийн хүсэмжит бүтээгдэхүүн байсан.





УВС ХҮНС ХК – БОНЗ-ын тунхаглалаа албан ёсоор баталсан.

Бид байгаль орчиндоо ээлтэй үйлдвэрлэл эрхлэх, нийгмийн өмнө хариуцлагатай байх, ил тод шударга засаглалыг төлөвшүүлэх зорилгоо олон нийтэд тунхагласан.

Бидний амлалт:

- 🎯 Байгальд ээлтэй, ногоон үйлдвэрлэлийг дэмжинэ
- 🎯 Орон нутгийн иргэд, ажилчдаа дэмжсэн нийгмийн хариуцлагатай оролцоо
- 🎯 Ил тод, шударга, авлигагүй засаглалын тогтолцоо
- 🌱 Бидний хийж буй нэг алхам – ирээдүйн тогтвортой хөгжил.



УВС ХҮНС ХК-ИЙН ЕРӨНХИЙ СТРАТЕГИ

Судалгаа хөгжлийн дээдэлэг оролцогч талуудын ашигт байдлыг хангах замаар тогтвортой хөгжлийн тогтолцоо.



БАЙГАЛЬ ОРЧНЫ АМЛАЛТ:

Экологийн цэвэр нөөцийг хариуцлагатай ашиглаж, судалгаа, инновацид тулгуурласан дэвшилтэт, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлнэ. Ус, эрчим хүчний хэрэглээ, хог хаягдлын менежментийг тасралтгүй сайжруулж, оролцогч талуудтай хамтран байгаль орчинд ээлтэй тариалан, үйлдвэрлэлийг явуулна.



НИЙГМИЙН АМЛАЛТ:

Оролцогч талууддаа БОНЗ-ийн зарчмыг сурталчлан таниулж, тогтвортой, эрүүл, аюулгүй, нутгийн иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлж, өс заншил, үлэмжлэлт өв соёлыг хадгалах үйл хэрэгт манлайлан оролцоно.



ЗАСАГЛАЛ АМЛАЛТ:

Компанийн засаглалын тогтолцоог ил тод, хариуцлагатай байдлаар хөгжүүлж, бүх шийдвэр гаргалтыг олон улсын стандарт болон хууль эрх зүйн шаардлагад нийцүүлэн явуулна. Оролцогч талуудын саналыг тогтмол хүлээн авч, жилд дор хаяж нэг удаа үүлзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, санал бодлыг үйл ажиллагаандаа тусгана.

Байгаль орчны зорилт:

1. Нийт эрчим хүчний хэрэглээний 10 хувийг 2027 оны 1 сар гэхэд сэргээгдэх эрчим хүчээр орлуулна.
2. Чацарганы модны биомассын хэмжээг МУИС-ийн Биологийн тэнхимтэй хамтран тооцож, Увс Хүнс ХК-ийн 100 га талбайн модны хүлэмжийн хийг шингээх чадварыг тодорхойлон, үр дүнг олон нийтэд тайлагнана.
3. Гадаргын усыг нөөцлөж хэмнэлттэйгээр ашиглах, дуслын системийн усалгааг эхний 10 га-д нэвтрүүлэх судалгааг 2026 оны 1 сард эхлүүлж, 2026 оны 12 сард судалгааны үр дүнг тайлагнана.
4. Үйлдвэрлэл болон тариалалтаас гарч буй нийт хог хаягдлын хэмжээг тодорхойлж, 100 хувь ангилан ялгана.

Нийгмийн зорилт:


- 2.1 Ханган нийлүүлэлтийн сүлжээ, бэлтгэн нийлүүлэгчдэд БОНЗ-ийн сургалтыг жил бүрийн 8 сард зохион байгуулна.
- 2.2 Жил бүр Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтанд бүх ажилтануудыг 100% хамруулах. Ажлын байрны осол гэмтлийг 0% болгоно.
- 2.3 Хөдөлмөрийн мөлжлөг, албадан хөдөлмөр эрхлэлтээс сэргийлж, ажилчидын эрх тэгш оролцоог хангана.
- 2.4 Оролцогч талуудын санал, гомдлыг ил тод, шүүрхай шийдвэрлэх нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, санал, гомдлыг 100% хувь шийдвэрлэх зорилгоор нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.
- 2.5 Компанийн нийгмийн хариуцлагын хөтөлбөрт орон нутгийн соёл, өс заншлыг тусгаж, олон нийтэд хэл соёлын болон биологийн олон янз байдлын үнэ цэнийг сурталчилна.
- 2.6 Хүнсний аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулж нутгийн ард иргэдийг чанартай хүнсээр хангах
- 2.7 Компанийн нийгмийн хариуцлагын хөтөлбөрт орон нутгийн соёл, өс заншлыг тусгаж, олон нийтэд хэл соёлын болон биологийн олон янз байдлын үнэ цэнийг сурталчилна.

Засаглалын зорилт:

- 3.1 БОНЗ тайланг олон улсын загвараар сайжруулан гаргаж, оролцогч талуудад танилцуулахын зэрэгцээ компанийн цахим хуудасанд нээлттэй байршуулна.
- 3.2 Авлига, ашиг сонирхлын зөрчлийг үл тэвчин, ил тод, шударга, хариуцлагатай засаглалыг хөгжүүлнэ.



"Увс Хүнс" ХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Нямгэрэл "Алтан гадас" одонгоор шагнагдлаа Монгол Улс Анхдугаар Үндсэн хуулиа батлан, Бүгд Найрамдах улсаа тунхагласны 101 жилийн ойн энэ эрхэм өдөр "Увс Хүнс" ХК-ийн Гүйцэтгэх захирал Л.Нямгэрэл нь хүнсний үйлдвэрлэлийн салбарт олон жилийн турш үнэтэй хувь нэмэр оруулж, салбартаа манлайлан ажилласныг үнэлж Монгол Улсын төрийн дээд "Алтан гадас" одонгоор шагнагдлаа.







“Увс Хүнс” ХК нь хэрэглэгчид та бүхэндээ улам ойртсоор, “Эрүүл хүнс – аз жаргалын эхлэл” уриатайгаар үйл ажиллагаа явуулдаг манай компанийн 100% Увсын чацарганаар хийгддэг, Газарзүйн заалттай Чацарганын тос, шүүс, чанамал, цай, жигнэмэг, чихэр болон бусад бараа бүтээгдэхүүнийг Шинэ Дарханы “Олон улсын худалдааны төв” болон “Хүслэн” бөөний төвд худалдаалах хамтын ажиллагааны гэрээг байгуулсан.



Нэгдсэн удирдлагын тогтолцоо

2018 оноос олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001:2015 стандарт, хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO 22000:2018 стандартуудыг хэрэгжүүлэн жил бүр хяналтын болон магадлан аудитыг амжилттай хийлгүүлэн ажиллаж байна. Байгаль орчин, Нийгэм, Засаглалын шаардлагыг ханган баталгаажуулалтын аудитад орохоор ажиллаж байна.

Эрсдэл, дотоод аудит

Дотоод аудитын хөтөлбөрийн аудитын төлөвлөгөө боловсруулан үйлдвэрийн нэгж, албадуудад дотоод аудит хийдэг. Эрсдлийн бүртгэл, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн арга хэмжээний хэмжилтийг ханган, удирдлагын дүн шинжилгээний хурлаар чанарын багт хэлэлцүүлэн шийдвэрээ гаргадаг.

Нийгмийн хариуцлага

Ажиллагсадын гэр бүлд шинээр мэндэлсэн хүүхдэд 300,000 төгрөгийн хадгаламж нээж, 38 хүүхэд хадгаламжтай боллоо. 2024 оны 05 дугаар сараас эхлэн нийт ажилтан бүрт хадгаламжийн данс нээн сар бүр 300,000 төгрөгийн хуримтлал үүсгэн 2025 оны 05 дугаар сард ажилтан бүрт жилийн хуримтлалыг тооцон олгон ажилласан.



Увс аймаг дахь Лидер сурагч академийн сурагчдийн илтгэл хэлэлцүүлгийн арга хэмжээг дэмжин ажилласан.



Увс аймгийн Хүүхдийн Зөвлөлийг Монголын Хүүхдийн Зөвлөлийн 2025 онд 2 дахь удаагаа майхант цугларалтад явахын өмнөхөн 1 удаагийн савлагаатай чацарганы өтгөрүүлсэн шүүснээс 600 ш буюу 60 хайрцгийг бэлэг болгон хандивлан Монголын өнцөг булан бүрээс ирсэн хүүхэд залуус МХЗ-ийн бүхий л гишүүдийн дархлааг дэмжин ажилласан.

~Увс Аймгийн Хүүхдийн Зөвлөл





Монголын ирээдүй болсон ахлах ангийн сурагчиддаа мэргэжлээ сонгоход нь чиг баримжаа өгөх зорилготой Увс аймгийн оюутны холбооны оюунлаг оюутнуудаа дэмжин хамтран ажилласан.





“Хүүхэд бүр ялагч-Хүүхэд бүр хамгаалагч” хүүхдийн марафон-2025 Увс аймагт амжилттай болж хамтран ажилласан.

✓“Хүүхэд бүр ялагч-Хүүхэд бүр хамгаалагч” гүйлтийн арга хэмжээг Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр ХЭҮК-оос Увс аймагт анх удаа амжилттай зохион байгуулж өндөрлөлөө.

✓Марафонд 6-18 насны 471 хүүхэд 6-9, 10-13, 14-18 насны ангиллаар оролцлоо. Марафон үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч хүндэтгэдэг, хүүхэд бүрт өөрийнх нь үнэ цэнийг нь мэдрүүлэх зорилгын дор өрнөсөн.

✓Тиймээс марафоны зэрэгцээ үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоох, түүний хор уршиг, сөрөг үр дагаврын талаар ойлголтоо нэмэгдүүлэх төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулж нийт 1 мянга гаруй хүүхдийг хамруулсан.

✓Хүүхдийн эрхийн төлөө сэтгэл, зүтгэл гарган хамтран ажилласан Увс аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Биеийн тамир, спортын газар, Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Увс Хүнс ХК зэрэг байгууллагуудтай хамтран ажилласан.

✓ХҮН БҮР ХҮҮХЭД ХАМГААЛАГЧ байхыг Хүний эрхийн Үндэсний Комиссоос уриалсан.





"Youth Power 2025 in Uvs"

Нэг. Увс аймаг нь байгалийн өвөрмөц тогтоц, цэнгэг усны нөөцөөрөө онцлог бүс нутаг боловч сүүлийн үед жил нэмэгдэх тусам уур амьсгалын өөрчлөлт, гадны нөлөөнөөс болж үүссэн байгаль орчны доройтол, гамшгийн эрсдэл нэмэгдэх хандлагатай байгаа юм.

"Youth Power 2025 in Uvs" энэ жилийн чуулганы маань онцлог нь Увс аймгийн хүүхдийн зөвлөлэй хамтарч 2025.10.26-10.27-ны өдөр 19 сумын 150 гаруй сурагчдад байгаль орчны хүрээнд залуучууд орон нутгийн тулгамдсан асуудлыг тодорхойлсон.

Хоёр. Увс аймагт тулгамдаж буй түгээмэл асуудлуудаар цахим асуулга явуулж Байгаль орчин, Боловсрол, Өв соёл, Харилцаа хандлага, Эрүүл мэнд, Хог хаягдал, Усны бохирдол, Гамшгаас хэрхэн урьдчилан сэргийлэх шийдлийн хүрээнд чуулган зохион байгууллаа.

Эдгээр сэдвээс Увс аймгийн бүх сумууд мөн аймгийн төвөөр түгээмэл үүсдэгээс гадна бидний амьдрал ахуйд нөлөөлдөг асуудлуудыг нийт оролцогч хүүхдүүдээр сонгуулан эдгээр 5 дэд сэдэв үлдсэн бөгөөд оролцогч нартайгаа сум сумуудийн ялгаа онцлогоос хамааран гаргаж авсан чухал асуудал мөн шийдлийг танилцуулж байна.

1. Усны нөөцийн бохирдол

Асуудал: Суурин газрын бохир ус, малын сэг зэи, ахуйн хог хаягдал гол мөрөн, булаг шанд руу орсноор усны чанар муудаж, ундны ус бохирдох мөн халдварт өвчин гарах эрсдэл нэмэгдэж байна.

Шийдэл: - Бохир ус цэвэрлэх байгууламжийг сайжруулж, бохир усыг шууд байгальд асгахгүй болгох

- Мал услах тусгай цэг байгуулж, голоос шууд услахыг хориглох

2. Усны хомсдол

Асуудал: Уур амьсгалын өөрчлөлт, хур тунадас багассантай холбоотойгоор гол, булаг ширгэж, ундны усны хүртээмж буурах аюул тулгараад байна.

Шийдэл: - Булаг, шандыг хамгаалалтын бүсэд оруулж хашаалах

- Ус хэмнэх зөв хэрэглээг нутгийн ард иргэдийн дунд хэвшүүлэх

3. Хог хаягдал

Асуудал: Хог хачгдалаас болж усны бохирдол үүсдэг. Хуванцар болон ахуйн хог хаягдлыг ил задгай хаяснаар борооны усаар дамжин гол, нуурт орж бохирдуулж байна.

Шийдэл: - Хог хаягдлыг ангилан ялгах систем нэвтрүүлэх

- Ил задгай хогийн цэгүүдийг хаах

4. Бэлчээрийн доройтлоос үүссэн усны доройтол

Асуудал: Бэлчээр хэт ашигласнаар хөрс элэгдэж, шороо тоос усанд орсноор ус булингартдаг.

Шийдэл: - Ээлжилж бэлчээрлэх тогтолцоог хэрэгжүүлэх

- Малыг тоог бэлчээрийн даацад тохируулах

5. Эрүүл мэнд, гамшгаас сэргийлэх

Асуудал: Залуусын дунд эрүүл мэндийн боловсрол дутмаг, гамшгийн үед хэрхэн өөрийгөө хамгаалах мэдлэг, дадал сул байна.

Шийдэл: Өөрөө өөрт өө хяналт хийж, эмчилгээ оношилгоонд орж, дасгал хөдөлгөөн хийх

"Youth Power in Uvs" байгальд ээлтэй залуусын чуулга уулзалтыг зохион байгуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан ивээн тэтгэгч байгууллагууд :

- Увс аймгийн засаг даргын тамгын газар, Улаангом сумын засаг даргын тамгын газар

- Увс аймгийн хүүхэд гэр бүл хөгжлийн газар, Увс аймаг дахь "Төрийн банкны" салбар

- "Хаан банкны" салбар, "Хас банкны" салбар, "Монгол банкны" салбар, "Голомт банкны" салбар, Увс аймаг дахь "Интерном" салбар, Увс аймаг дахь "Skytel" салбар, Ундарга увс ХК

- Увс хүнс ХК, Өнхөрүүш бэйкери, Сондор кофе шоп, Түмэн нээлттэй ТНХ, Чандмань Увс ХХК



Бүтээгдэхүүн

“Увс Хүнс” ХК 2025 онд дараах шинэ бүтээгдэхүүнийг гаргалаа.

Гурилан бүтээгдэхүүн





Шар сүүний иштэй чихэр



Хандтай хундагатай Хан Хөхий архи



330 мл савлагаатай цэвэр ус







Увс аймгийн 100 жилийн ойн хүрээнд зочдын бэлгийн сонголтод Монконди компанитай хамтран шинэ бүтээгдэхүүн болох чацарганатай хатуу чихрийг худалдаанд гаргалаа.




“Саян” шоколадны үйлдвэртэй хамтран чацаргана, арвайн гурил, нэрс агуулсан “Улаангом” шоколад үйлдвэрлэн гаргасан. Цайны хужир мөн бэлгийн сонголтод савлан гаргав.





Байгаль дэлхийн гайхамшиг, чацарганы өлгий нутаг Увсаас танд зориулав
Увс нутгийн нэрийн хуудас болсон, газарзүйн заалттай, **100%** Чацарганы тостой саванг
Бүх насныханд зориулан гаргалаа. Олон удаагийн туршилтын үр дүнд “Арьсны эмч”
Чацарганатай саванг Монгол хонины сүүлэн тостой зохист харьцаатайгаар хольсон нэн
тааламжит орцтой тул нүүр болон биенд хэрэглэхэд тохиромжтой.



Герман технологиор үйлдвэрлэсэн, шим тэжээлээр баялаг Чацаргана, Ухрийн нүд, Нэрс 3 төрлийн
жимсний чанамлыг багц болгон танд санал болгож байна.





Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн
гарын үсэг, огноо: 2026.04.23

Овог, нэр: Л.Нямгэрэл

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: О.Оюунхүү

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: